

Лити-ион батареин аюулууд

2023 оны 9-р сар



1-р зураг: Лити-ион батареин галын улмаас барилгууд гэмтсэн.



2-р зураг: Лити-ион батареи шатаж буй байдал

Ашиглалтын хугацаа урт, хүчин чадал маш сайн, засвар үйлчилгээ шаарддаггүй, жин багатай зэрэг давуу талтай тул сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд лити-ион батареи үйлдвэрлэлийн зориулалтаар өргөнөөр ашиглаж байна. Давуу тал ихтэй тул үр ашиг сайтай, зардал багатай. Гэсэн хэдий ч сул талыг нь ч бас тооцож үзэх хэрэгтэй. Хориотой газарт ашиглах төхөөрөмжийн төрлийг солих, батлахдаа нэмэлт аюулуудыг тодорхойлж, сайтар ойлгож, анхаарч үзэх шаардлагатай.

Бид энэхүү мэдээллээр лити-ион батареитай холбоотой осол зөрчлөөс авсан сургамжийг та бүхэнд танилцуулж, лити-ион батареи шатах, дэлбэрэх эрсдэлийг ойлгож авах, урьдчилан сэргийлэх талаар зарим зөвлөмжийг өгөх болно.

2023 оны 7-р сарын мэдээллээс батареигаар ажилладаг төхөөрөмж гал түймрийн эх үүсвэр болдог бөгөөд тэдгээр төхөөрөмжийг хориотой газарт хэрхэн ашиглах талаарх зөвлөмжийг хараарай.

<https://www.aiche.org/ccps/resources/process-safety-beacon/archives>

Та мэдэх үү?

- Лити-ион батареи зөөврийн компьютер, камер, ухаалаг утас зэрэг өргөн хэрэглээний олон төрлийн төхөөрөмжид ашиглах болсон тул батареинаас үүдэлтэй гал түймрийн тохиолдол ихсэж байна.
- Төхөөрөмжийг цэнэглэх үед аюул нэмэгддэг. Мөн өндөр хүчин чадалтай батареины гал түймрийн аюул нь өндөр байна.
- Лити-ион батареи хурдан, эрчимтэй шатдаг бөгөөд галын тархалтыг хязгаарлах, унтраахад хэцүү байдаг. Мөн хортой утаа, хий ялгаруулахаас гадна дэлбэрэх эрсдэлтэй байдаг. Галыг унтраасны дараа ч дахин гал авалцах эрсдэлтэй тул хөл хорио тогтоох, ажиглах шаардлагатай.
- Үйлдвэрийн гологдолтой байх, гаднын нөлөөгөөр гэмтэх, буруу ашиглах, ашиглалтын хугацаа дуусах зэрэг нь гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- Лити-ион батареитай зөв харьцах тухай зөвлөгөөг хаанаас ч олох боломжтой (жишээ нь: <https://www.usfa.fema.gov/a-z/lithium-ion-batteries.html>)
- Онцгой байдлын ажилтныг лити-ион батареин галыг унтраах аргачлалд сургаж бэлдсэн байх ёстой. Underwriter's Laboratories (UL) байгууллагын цахим сургалт (<https://ul.org/research/electrochemical-safety/battery-safety-science-webinar-series>)

Та юу хийх ёстой вэ?

- Цахим төхөөрөмжийг нэр хүндтэй борлуулагчаас худалдан авч, эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, тухайн төхөөрөмжид тохирсон батареи, цэнэглэгч ашигла.
- Гал гарсан үед аюулгүй байдлаа хангасан тохиолдолд батареи тэжээлийн эх үүсвэрээс салга. Тухайн орчныг орхин гарч онцгой байдлын албанд дуудлага өг. Галыг унтраах оролдлого БҮҮ ХИЙ.
- Батареид тогтмол үзлэг хийж, батареи хагараагүй, хөөгөөгүй, гоожоогүй болохыг баталгаажуул.
- Лити-ион батареи цэнэглэх үед дулаан ялгардаг. Батареи цэнэглэхдээ агааржуулалт сайтай газар, хатуу гадаргуу дээр тавьж цэнэглэ. Лити-ион батареи бүхий төхөөрөмжийг цэнэглэхдээ аюулгүй газарт, байнгын хараа хяналттай байлга. Батареи бүрэн цэнэглэгдэж дуусмагц тэжээлийн эх үүсвэрийг салга.
- Лити-ион батареи энгийн хог хаягдалтай хамт хаяж хэрхэвч болохгүй. Тусгай хог хаягдлын цэгт хүлээлгэн өгөх ёстой. Орон нутгийн хог хаягдал боловсруулах албанаас зөвлөгөө ав.
- Хэрэв та үйлдвэрийн орчинд батареи бүхий төхөөрөмж ашигладаг бол зөвхөн зөвшөөрөгдсөн газарт ашигла. Шатамхай материалтай ойртуулж болохгүй.

Лити-ион батареин гал түймрээс сэргийлье!